

ДЭМБ-ЫН ТАМХИНЫ
ХЯНАЛТЫН СУУРЬ
КОНВЕНЦ




13 дугаар зүйлийг
хэрэгжүүлэх
Удирдамж



FCTC

WHO FRAMEWORK CONVENTION
ON TOBACCO CONTROL



ДЭМБ-ЫН ТАМХИНЫ ХЯНАЛТЫН СУУРЬ КОНВЕНЦ

13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх удирдамж:

“Тамхины зар сурталчилгаа,
дэмжлэг, ивээн тэтгэх үйл
ажиллагааг хориглох тухай”

Эх хувилбартай дараах хаягаар танилцана уу:

<https://fctc.who.int/publications/m/item/tobacco-advertising-promotion-and-sponsorship>

ДЭМБ-ЫН ТХСК-ИЙН 13 ДУГААР ЗҮЙЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДАМЖ

ТАМХИНЫ ЗАР СУРТАЛЧИЛГАА, ДЭМЖЛЭГ, ИВЭЭН ТЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ХОРИГЛОХ ТУХАЙ

ЗОРИЛГО, ЗОРИЛТ

Энэхүү удирдамжийн зорилго нь ДЭМБ-ын Тамхины хяналтын суурь конвенцид нэгдэн орсон Оролцогч талуудад уг конвенцийн 13 дугаар зүйлийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд нь туслах явдал юм. Удирдамж нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг үр дүнтэй арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн Оролцогч талуудын тэргүүн туршлага, нотолгоонд үндэслэсэн болно. Тус баримт бичиг нь Оролцогч талуудад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг Иж бүрэн хориг тавих, хэрэгжүүлэх удирдамж болох бөгөөд Үндсэн хууль болон бусад хуулиндаа заасан зарчмын улмаас иж бүрэн хориг арга хэмжээ авч хэрэгжүүлэх боломжгүй Оролцогч талуудад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг аль болох бүрэн хориг тавих удирдамжийг өгнө.

Эдгээр удирдамж нь улс орны дотоодод болон олон улсын түвшинд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг үр дүнтэй бууруулахын тулд конвенцийн 13 дугаар зүйлийг хэрэгжүүлэх хамгийн шилдэг арга замыг хангаж өгнө.

Үүнд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- (а) Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны нөлөөгөөр тамхины хэрэглээ өсдөг бөгөөд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд бүрэн хориг тавьснаар тамхины хэрэглээ буурдаг болох нь баримтаар нотлогдсон зүйл.
- (б) Конвенцид нэгдэн орсон Оролцогч талууд тус конвенцийн 13.1, 13.2 дугаар зүйлд хүлээн зөвшөөрсний дагуу тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг үр дүнтэй хориг нь *бүх төрлийн* тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хамарсан *өргөн хүрээтэй* байх ёстой.
- (в) Конвенцийн 1 дүгээр зүйлд заасан тодорхойлолтын дагуу тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг хориг нь тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээг *шууд* болон *шууд бусаар* сурталчлах *зорилго, нөлөө бүхий* эсвэл *ийм нөлөө үзүүлж болохуйц бүх төрлийн арилжааны харилцаа холбоо, зөвлөмж, үйл хэрэг* болон тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээг *шууд* болон *шууд бусаар* сурталчлах *зорилго, нөлөө бүхий эсвэл ийм нөлөө үзүүлж болохуйц арга хэмжээ, үйл ажиллагаа болон хувь хүнд өргөх бүх төрлийн хандивт* хамаарна.
- (г) Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хориг гэдэгт *хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа* мөн хамаарна. Үүнд конвенцид нэгдэн орсон Оролцогч талын улс орноос гаралтай болон тус улс оронд хэрэглэж буй гадны зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа мөн хамаарна.

- (д) Үр нөлөөтэй байх үүднээс бүрэн хориг нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг явуулахад оролцоотой бүх хүн, аж ахуйн нэгжид хамаарна.
- (е) Олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, таниулах хүчтэй хөтөлбөрийн дэмжлэг, зохицуулалт бүхий үр дүнтэй хяналт, хэрэгжилт, хориг арга хэмжээ зэрэг нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хоригийг хэрэгжүүлэхэд нэн чухал.
- (ё) Иргэний нийгэм нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаарх хууль тогтоомжид дэмжлэг үзүүлэх, боловсруулах болон тэдгээрийн хэрэгжилтийг хангахад голлох үүрэгтэй бөгөөд энэ үйл явцад идэвхтэй хамтрагч байх ёстой.
- (ж) Улс орны дотоод дахь болон хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг арилгахад үр дүнтэй олон улсын хамтын ажиллагаа нэн чухал.

БҮРЭН ХОРИГИЙН ХАМРАХ ХҮРЭЭ

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, Ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хоригийн хамрах хүрээний талаар дор “Тойм” гэсэн гарчигтай дэд хэсэгт өгүүлсэн бөгөөд түүний удаах “Жижиглэнгийн худалдаа, үзүүлэн”, “Тамхины худалдааны хүрээн дэх харилцаа холбоо” хэсэгт уг бүрэн хоригийг нэвтрүүлэхэд бодлого зохицуулагчдад тулгарч болох онцлог бэрхшээлийн талаар авч үзсэн болно.

Тойм

Зөвхөн хамрах хүрээ нь өргөн байх тохиолдолд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг хориг үр дүнтэй байдаг. Орчин цагийн маркетингийн харилцаа холбоонд шууд маркетинг, олон нийтийн харилцаа, борлуулалтын сурталчилгаа, биет худалдаа болон интерактив онлайн маркетингийн арга гэх мэт бараа бүтээгдэхүүний борлуулалт болон худалдан авалтын зар сурталчилгааны нэгдсэн арга ордог. Хэрвээ тамхины шууд зар сурталчилгааны зөвхөн тодорхой хэлбэрүүдийг хоригловол тамхи үйлдвэрлэгчид гарцаагүй зарцуулалтаа өөрчилж, бүтээлч, шууд бус арга замыг ашиглан ялангуяа залуучуудын дунд тамхины хэрэглээ, тамхин бүтээгдэхүүнийг сурталчлах бусад хэлбэрийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны стратегийг баримталж эхэлнэ.

Тиймээс тамхины хэрэглээний сурталчилгаанд хэсэгчлэн тавьсан хоригийн үр дүн хязгаарлагдмал байдаг. Конвенцийн 13 дугаар зүйлд үүнийг харгалзан үзэж, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох ерөнхий үүргийг тус зүйлд тогтоосон байна. Конвенцийн 13.1.1-д “Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг бүрэн хориглосноор тамхин бүтээгдэхүүний хэрэглээг багасгана гэдгийг Оролцогч талууд хүлээн зөвшөөрнө” хэмээн заасан байна.

Конвенцийн 13.1 болон 13.2-т заасан бүрэн хоригийг хэрэгжүүлэхийн тулд Оролцогч талууд тус конвенцийн 1(с), 1(г) заалтад тодорхойлсон байдлаар тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглоно. Конвенцийн 1(с) заалтад “тамхины зар сурталчилгаа, дэмжлэг” гэдгийг “тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээг *шууд* болон *шууд бусаар* сурталчлах

зорилго, нөлөө бүхий эсвэл ийм нөлөө үзүүлж болохуйц бүх төрлийн арилжааны харилцаа холбоо зөвлөмж, үйл хэрэг” хэмээн тодорхойлсон бол “тамхины ивээн тэтгэх үйл ажиллагаа” гэдгийг “тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээг шууд болон шууд бусаар сурталчлах зорилго, нөлөө бүхий эсвэл ийм нөлөө үзүүлж болохуйц арга хэмжээ, үйл ажиллагаа болон хувь хүнд өргөх бүх төрлийн хандив” хэмээн тодорхойлсон байна.

“Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг” болон “тамхины ивээн тэтгэх үйл ажиллагаа” гэдэг нь дан ганц тодорхой төрлийн тамхин бүтээгдэхүүнд бус тамхины ерөнхий хэрэглээнд; зөвхөн сурталчилгааны зорилго бүхий үйл ажиллагаанд бус сурталчилгааны нөлөө бүхий, сурталчилгааны нөлөө үзүүлж болохуйц үйл ажиллагаанд; дан ганц шууд сурталчилгаа бус дам сурталчилгаанд ч мөн адил хамаарна гэдгийг тэмдэглэн хэлэх нь зүйтэй. “Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг” гэдэг нь дан ганц “харилцаа холбоо”-гоор хязгаарлагдахгүй бас “зөвлөмж”, “үйл ажиллагаа”-г ч мөн агуулах бөгөөд эдгээр нь дараах зүйлийг хамарна. Үүнд: (а) борлуулалт, түгээлтийн төрөл бүрийн зохион байгуулалт¹, (б) төрөл бүрийн хэвлэл мэдээллийн агуулгад тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээний талаар хавчуулах зэрэг далд хэлбэрийн зар сурталчилгаа, дэмжлэг, (в) тамхин бүтээгдэхүүнийг аливаа арга хэмжээтэй, эсвэл өөр бүтээгдэхүүнтэй төрөл бүрийн арга хэлбэрээр холбох, (г) сурталчилгааны савлагаа болон бүтээгдэхүүний дизайн гаргах, (д) янжуур тамхи болон бусад төрлийн тамхитай ижил төстэй хэлбэр бүхий чихэр, тоглоом зэрэг зүйлсийг үйлдвэрлэх болон түгээх² зэрэг хамаарна. Түүнчлэн “тамхины ивээн тэтгэх үйл ажиллагаа” хэмээх тодорхойлолтод олон нийтэд зарлан мэдэгдсэн эсэхээс үл хамааран санхүүгийн болон бусад “бүх хэлбэрийн хандив” хамаарна гэдгийг тэмдэглэх нь чухал.

Сурталчилгааны шууд болон шууд бус нөлөө нь тамхи үйлдвэрлэгч болон тамхи импортлогчийн брэндийн нэр, худалдааны тэмдэг, лого, нэр болон тамхин бүтээгдэхүүн, тамхи үйлдвэрлэгч, тамхи импортлогчтой холбоотой енге, өнгөний хослол гэх мэт үг хэллэг, дизайн, дүрс, дуу авиа, өнгө болон үг хэллэг, дизайн, дүрс, болон өнгөний тодорхой нэг хэсгийг хэрэглээгээр бий болно. Брэндийн нэр эсвэл худалдааны тэмдэг хэрэглээгүй тамхины компаниудын өөрсдийнх нь сурталчилгаа (байгууллагын сурталчилгаа ч гэж нэрлэглэх нь бий) нь мөн тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээний нэг хэлбэрийн сурталчилгаанд тооцогдоно. Тамхи ороодог цаас, тамхины шүүлтүүр, тамхи орооход хэрэглэдэг төхөөрөмж, дууриамал тамхин бүтээгдэхүүн зэрэг тамхины дагалдах хэрэгслийг харуулсан, санхүүжүүлсэн зар сурталчилгаа нь мөн тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээний зар сурталчилгаатай адил нөлөөтэй гэж үздэг.

Хууль тогтоомжоор бүрэн эсвэл бүрэн гэж тооцогдож болох хориотой үйл ажиллагааны жагсаалт гаргахаас зайлсхийх хэрэгтэй. Хууль тогтоомжид хориотой үйл ажиллагааны жишээг дурдах нь хэрэгцээтэй байдаг боловч энэ нь

¹ Жишээлбэл: жижиглэнгийн худалдаачдад үзүүлэх урамшууллын тогтолцоо, борлуулалтын цэгүүдэд самбар гаргах, сугалаа, үнэгүй бэлэг, бүтээгдэхүүний үнэгүй дээж, хямдрал, өрсөлдөөн (тамхин бүтээгдэхүүний худалдан авалттай холбоотой болон холбоогүй), тамхин бүтээгдэхүүн худалдан авсан тохиолдолд дагалдуулан олгох ашиглаж болох тасалбар гэх мэт урамшуулал, хөнгөлөлтийн арга.

² Үүгээр конвенцийн 16.1-р заалтын санааг илэрхийлсэн болно. Уг заалтаар "дотоодын хууль тогтоомж болон үндэсний хууль тогтоомжоор тогтоосон нас буюу 18 наснаас доош насны хүүхдэд тамхин бүтээгдэхүүн худалдаалахыг хориглосон хууль тогтоох, гүйцэтгэх, захиргааны болон бусад арга хэмжээг төрийн зохистой шатанд авч, хэрэгжүүлэх" үүргийг Оролцогч талуудад ногдуулдаг бөгөөд "эдгээр арга хэмжээнд [...] (в) бага насны хүүхэд, залуучуудын сэтгэлийг татах гадна хэлбэр төрхөөрөө тамхин бүтээгдэхүүнтэй төстэй чихэр, зууш, тоглоом болон бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийг хориглох зэрэг арга хэмжээ орно" хэмээн заасан байдаг.

зөвхөн жишээ төдий бөгөөд хориотой үйл ажиллагааг бүрэн дүүрэн хамраагүй гэдгийг тодорхой заах хэрэгтэй. Үүнийг "...гэх мэт гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй..." гэх мэт бусад эсвэл аливаа хэлбэрийн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа" зэрэг хэллэгүүдийг ашиглан тодорхой зааж болно.

Конвенцийн 13 дугаар зүйлд заасан уг хоригт хамаарах зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны жишээ хэлбэрүүдийн жагсаалтыг (бүрэн биш) энэхүү удирдамжийн хавсралтад оруулав.

Зөвлөмж

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тавих бүрэн хоригт дараах зүйлсийг хамруулбал зохино. Үүнд:

- тамхины бүх төрлийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа;
- шууд болон шууд бус зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа;
- сурталчилгааны зорилготой, сурталчилгааны нөлөөтэй, сурталчилгааны нөлөө үзүүлж болохуйц үйлдэл;
- тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээний сурталчилгаа;
- арилжааны харилцаа холбоо, зөвлөмж, үйл ажиллагаа;
- аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хувь хүнд өргөх хандив;
- тамхины брэнд нэрийн зар сурталчилгаа, дэмжлэг болон байгууллагын сурталчилгаа;
- уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгсэл (хэвлэл, зурагт, радио) болон интернэт, гар утас, бусад шинэ технологи, хальс гэх мэт мэдээллийн бусад хэрэгсэл.

Жижиглэнгийн худалдаа, үзүүлэн

Худалдааны цэгүүдэд тавьсан тамхин бүтээгдэхүүний үзүүлэн өөрөө зар сурталчилгаа, дэмжлэгт тооцогдоно. Бүтээгдэхүүнийг ийнхүү дэлгэн харуулах нь тамхин бүтээгдэхүүнийг худалдан авах сэдэл бий болгож, тамхины хэрэглээ нийгэмд хүлээн зөвшөөрөгдсөн зүйл мэт сэтгэгдэл төрүүлэн, тамхи татдаг хүмүүсийг тамхинаас гарах аргагүй болгох замаар тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээний үндсэн сурталчилгаа болдог. Дэлгэн харуулсан бүтээгдэхүүний сурталчилгааны нөлөөнд бага залуу насны хүмүүс илүү их өртдөг.

Тамхин бүтээгдэхүүний борлуулалтын цэгүүдэд сурталчилгааны аливаа элемент байлгахгүй байх явдлыг хэвшүүлэхийн тулд Оролцогч талууд жижиглэн худалдааны дэлгүүр болон гудамжны мухлаг зэрэг тамхин бүтээгдэхүүн борлуулдаг цэгүүдэд тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн харуулахыг бүрмөсөн хориглох хэрэгтэй. Зөвхөн сурталчилгааны элемент агуулаагүй, бүтээгдэхүүний нэр болон үнийн жагсаалт гаргахыг зөвшөөрч болно. Конвенцийн 13 дугаар зүйлд тусгагдсан бүхий л асуудлын адилаар уг хориг нь усан онгоц, агаарын хөлөг, боомт болон нисэх буудлуудад мөн адил хамаарна.

Конвенцийн нөхцөлөөр тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах автомат машин нь өөрөө биетээр зар сурталчилгаа, дэмжлэгийн нэг арга хэрэгсэл болдог тул ийм төрлийн машиныг хориглох нь зүйтэй.³

Зөвлөмж

Худалдаа, борлуулалтын цэгт тамхин бүтээгдэхүүнийг биетээр дэлгэн харуулах нь зар сурталчилгаа, дэмжлэгт тооцогддог тул үүнийг хориглох хэрэгтэй. Тамхин машин нь өөрөө бүтээгдэхүүн худалдаалах автомат биетээр зар сурталчилгаа, дэмжлэгийн нэг арга хэрэгсэл болдог тул ийм төрлийн машиныг хориглох нь зүйтэй.

Савлагаа болон бүтээгдэхүүний онцлог⁴

Савлагаа бол зар сурталчилгаа, дэмжлэгийн нэг чухал элемент. Тамхины савлагаа буюу бүтээгдэхүүний онцлогийг хэрэглэгчдийг татах, бүтээгдэхүүнийг сурталчлах, брэндийн таних тэмдэг бий болгон сурталчлах зэрэг төрөл бүрийн зорилгоор ашигладаг, тухайлбал тамхины савлагаа, янжуур болон бусад тамхин бүтээгдэхүүнд лого, өнгө, загвар, зураг, дүрс болон материал ашиглах.

Эрх бүхий байгууллагаас заасанчлан тамхины бүтээгдэхүүний хайрцаг, сав, баглаа, боодол нь хар, цагаан эсвэл өөр 2 эсрэг тэсрэг өнгөний хослолтой байх, бүтээгдэхүүний савлагаан дээр эрүүл мэндийн анхааруулга, татварын тамга, төрөөс шаардсан бусад мэдээллээс гадна брэндийн нэр, бүтээгдэхүүний нэр, үйлдвэрлэгчийн нэр, холбоо барих мэдээлэл болон бүтээгдэхүүний чанараас өөр мэдээлэл, лого агуулаагүй, бичвэрийн хэлбэр, хэмжээ, дүрс, материал зэрэг нь шаардсан стандартын дагуу энгийн савлагаатай байх шаардлага тавих замаар тамхины савлагааны сурталчилгааны нөлөөг бууруулж болно. Савлагааны дотор талд эсвэл савлагаан дотор, доторх ширхэгийн янжуурт болон өөр бусад тамхинд наасан буюу хавсаргасан зар сурталчилгаа байх ёсгүй.

Хэрэв энгийн савлагааг албан ёсоор шаардаагүй бол бүтээгдэхүүний дизайны онцлогт амьтны буюу өөр бусад дүрс, "хөгжилтэй" үг хэллэг, тамхины өнгийн цаас, сэтгэл татам үнэр, шинэлэг зүйл, улирлын чанартай савлагаа гэх мэт хэрэглэгчдийг татах зүйлс оруулахыг хориглох зэргээр аль болох олон хориг тавих хэрэгтэй.

Зөвлөмж

Савлагаа болон бүтээгдэхүүний дизайн бол сурталчилгааны чухал элемент болдог. Савлагааны сурталчилгааны нөлөөг бууруулахын тулд Оролцогч талууд энгийн савлагаа хэрэглэх шаардлага тавих асуудлыг харгалзан үзэх хэрэгтэй. Савлагаа, савлагаан доторх янжуур тамхи болон бусад төрлийн тамхи нь тухайн бүтээгдэхүүнийг улам сэтгэл татам болгох аливаа сурталчилгааг агуулаагүй байх шаардлагатай.

³ Тамхин бүтээгдэхүүнийг худалдаалах автомат машин нь өөрөө тамхины зар сурталчилгаа, дэмжлэг болдог тул ийм төрлийн машиныг хориглох нь бага насны хүүхдийг хамгаалах тухай конвенцийн 16-р зүйлтэй нийцнэ. 16.1-д заасан авч хэрэгжүүлж болох арга хэмжээнд "Оролцогч талуудын харьяа нутаг дэвсгэрт буй тамхи худалдаалах автомат машин нь бага насныханд хүртээмжгүй байж, улмаар бага насны хүүхдэд тамхин бүтээгдэхүүний борлуулалтын сурталчилгаа болохгүй байх" хэмээн заажээ. Мөн конвенцийн 16.5-д "Заавал биелүүлэх тунхагийг бичгээр үйлдэн, өөрийн харьяа нутаг дэвсгэрт тамхи борлуулах автомат машин байлгахыг хориглох буюу ийм төрлийн машиныг бүр мөсөн хориглох замаар Оролцогч талууд хүчин чармайлтаа харуулж болно" гэжээ.

⁴ Эрүүл мэндийн анхааруулга болон ташаа мэдээллийн талаарх асуудлыг хөндсөн, энгийн савлагааны тухай конвенцийн 11-р зүйлийн хэрэгжилтийн удирдамжийг харна уу.

Интернэт борлуулалт

Конвенцид тодорхойлсончлон тамхийг интернэтээр худалдан борлуулах нь тамхи, тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгаа, дэмжлэгтэй зайлшгүй холбогддог. Энд дан ганц зар сурталчилгаа, дэмжлэгийн асуудал ч бус, бага насны хүүхдэд тамхи худалдан борлуулах, татвараас зайлсхийх, хууль бус худалдаа зэрэг асуудлууд гардаг.

Интернэтээр тамхины зар сурталчилгаа явуулахаас зайлсхийх хамгийн үр дүнтэй арга бол интернэтээр тамхи худалдаалахыг хориглох арга юм.⁵ Энэ хориг нь зөвхөн бүтээгдэхүүнийг худалдан борлуулдаг байгууллагад бус, бүтээгдэхүүний төлбөр, шуудангийн болон хүргэлтийн үйлчилгээ хариуцсан байгууллагуудад ч мөн адил хамаарах ёстой.

Интернэтээр тамхи, тамхин бүтээгдэхүүнийг худалдан борлуулах явдлыг хараахан хориглоогүй байгаа тохиолдолд зураг болон сурталчилгааны бусад шинжийг агуулаагүй дан ганц бүтээгдэхүүний нэр болон үнийн үгэн жагсаалт гаргахыг зөвшөөрч, хязгаарлалт хийх нь зүйтэй.

Интернэтээр явагддаг тамхи, тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгаа, дэмжлэгийн далд мөн чанар болон түүнийг хийж буй эздэд хүрэхэд хүндрэлтэй байдлыг харгалзан дээрх арга хэмжээг үр дүнтэй болгоход дотоодын онцгой нөөц шаардлагатай. FCTC/COP3(14) шийдвэрт санал болгосон хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг бууруулах, ялангуяа холбоо сүлбээний цэгүүдийг олж тогтоон, бусад Оролцогч талуудын мэдэгдэлтэй харьцах арга хэмжээнүүд нь улс орны дотоодод хориг, хязгаарлалтыг хэрэгжүүлэх хүчин чармайлтын хүчийг нэмэгдүүлнэ.

Зөвлөмж

Тамхийг интернэтээр худалдан борлуулах нь тамхи, тамхин бүтээгдэхүүний сурталчилгаатай зайлшгүй холбогддог тул интернэтийн худалдааг хориглох шаардлагатай.

Брэндийг өргөтгөх, брэнд хуваалцах

“Брэнд өргөтгөх” гэдэг нь тамхи, тамхин бүтээгдэхүүний брэндийн нэр, эмблем, худалдааны тэмдэг, лого, худалдааны ялгах тэмдэг болон бусад ялгарах онцлог (ж.нь, өнгөний онцлог хослол)-ийг тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээтэй тухайн тамхи, тамхин бүтээгдэхүүн холбоотой мэтээр ашиглахыг хэлнэ.

“Брэнд хуваалцах” гэдэг нь тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээний брэндийн нэр, эмблем, худалдааны тэмдэг, лого, худалдааны ялгах тэмдэг болон бусад ялгарах онцлог (ж.нь, өнгөний онцлог хослол)-ийг тамхи, тамхин бүтээгдэхүүн, тамхины компанитай тухайн тамхин бус бүтээгдэхүүн, үйлчилгээ холбоотой мэтээр ашиглахыг хэлнэ.

“Брэнд өргөтгөх” болон “Брэнд хуваалцах” явдал нь шууд болон шууд бус байдлаар тамхин бүтээгдэхүүн болон тамхины хэрэглээг сурталчлах зорилго, нөлөө бүхий, эсвэл ийм нөлөө үзүүлж болохуйц байх тохиолдолд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг гэж үзнэ.

⁵ Интернэтээр тамхи худалдаалах явдлыг зохицуулах бусад аргуудын талаар Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааны протокол хариуцсан Засгийн газар хоорондын хэлэлцээрийн байгууллага авч хэлэлцэж байгаа.

Зөвлөмж

"Брэнд өргөтгөх" болон "Брэнд хуваалцах" явдал нь тамхи, тамхин бүтээгдэхүүний зар сурталчилгаа, дэмжлэгийн нэг арга хэрэгсэл учраас Оролцогч талууд үүнийг хориглох нь зүйтэй.

Байгууллагын нийгмийн хариуцлага⁶

Тамхины компаниудын хувьд хандив өргөх болон өөрийн бизнесийн үйл ажиллагааны "нийгмийн хариуцлага"-ыг сурталчлах замаар сайн байгууллагын дүр төрх бүтээхийг хичээх нь тун элбэг.

Зарим тамхины компани шууд эсвэл өөр байгууллагаар дамжуулан нийгмийн, эрүүл мэндийн, халамжийн, эсвэл байгаль орчны байгууллагуудад санхүүгийн болон эд материалын хандив тусламж үзүүлдэг. Ийм хандив тусламж нь конвенцийн 1(g) дүгээр зүйлд заасан тамхины ивээн тэтгэх үйл ажиллагааны тодорхойлолтод хамаарах бөгөөд ийм хандив тусламжийн зорилго, үр нөлөө, үзүүлж болох нөлөө нь шууд болон шууд бус байдлаар тамхин бүтээгдэхүүн, тамхины хэрэглээг сурталчилдаг тул бүрэн хоригийн хүрээнд хориглох нь зүйтэй.

Тамхины компаниуд бусдад хандив тусламж өгөхгүйгээр өөрсдөө "нийгмийн хариуцлагатай" (ажил олгогч, ажилтны сайн харилцаа тогтоох, байгальд ээлтэй технологи нэвтрүүлэх г.м.) бизнесийн үйл ажиллагаа эрхэлж болзошгүй. Ийм үйл ажиллагааны зорилго, үр нөлөө, үзүүлж болох нөлөө нь шууд болон шууд бус байдлаар тамхин бүтээгдэхүүн, тамхины хэрэглээг сурталчлах явдал байдаг тул эдгээр үйл ажиллагааг нийтэд сурталчлахыг хориглох хэрэгтэй. Байгууллагын тайлан мэдээ (жилийн тайлан г.м.), бизнесийн удирдлагын (ажилтан элсүүлэх, нийлүүлэгчидтэй харилцах г.м.) зорилгоос бусад тохиолдолд ийм төрлийн мэдээллийг нийтэд мэдээлэхийг хориглох нь зүйтэй.

"Залуучуудыг тамхи татахаас урьдчилан сэргийлэх кампанит ажил" зэрэг тамхины үйлдвэрийн олон нийтийн боловсролын кампанит ажлыг өөр байгууллага хийх тохиолдолд "ивээн тэтгэх үйл ажиллагаа"-нд тооцож, харин тамхины үйлдвэр өөрөө хийсэн тохиолдолд байгууллагын шууд сурталчилгаанд тооцогдох тул ийм үйл ажиллагааг хориглох хэрэгтэй.

Зөвлөмж

Тамхины компаниуд өөр бусад байгууллагад "нийгмийн хариуцлагын шалтгаанаар" хандив тусламж өгөх нь тамхины ивээн тэтгэх үйл ажиллагааны нэг хэлбэр болох учраас Оролцогч талууд үүнийг хориглох хэрэгтэй. Тамхины үйлдвэрийн "нийгмийн хариуцлагатай" бизнесийн үйл ажиллагааг сурталчлах нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэгт тооцогдох тул үүнийг хориглох хэрэгтэй.

Хууль ёсны илэрхийлэл

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хориг нь сэтгүүлзүй, уран сайхан, эрдэм шинжилгээний хууль ёсны илэрхийлэл, нийгмийн болон улс төрийн хууль ёсны тайлбар (тухайлбал, тамхитай холбоотой мэдээлэл бүхий дүрс санамсаргүй байдлаар хэвлэл мэдээллээр цацагдах, түүхэн хүний дүрслэл, бодлогын талаар үзэл бодлоо

⁶ Талуудын бага хурлын үеэр байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан конвенцийн 5.3-р зүйлийн удирдамжид тамхины хяналт болон нийгмийн эрүүл мэндийн бодлогыг тамхины үйлдвэрийн арилжааны болон бусад ашиг сонирхлоос хамгаалах байр сууринаас энэхүү асуудлыг авч үзсэн байна.

илэрхийлэх)-т саад болох учиргүй. Гэхдээ зохих тайлбар, сануулга хийх шаардлагатай байж болно.

Зарим тохиолдолд сэтгүүлзүй, уран сайхан, эрдэм шинжилгээний хууль ёсны илэрхийлэл, нийгмийн болон улс төрийн хууль ёсны тайлбар нь редакцын, уран сайхны нийгмийн болон улс төрийн шалтгааны үндэслэлгүй Энэ тохиолдолд элементүүдийг агуулж байж болно. сэтгүүлзүй, уран сайхан, эрдэм шинжилгээний хууль ёсны илэрхийлэл, нийгмийн болон улс төрийн хууль ёсны тайлбар гэхээсээ илүүтэй тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа гэж үзнэ. Тухайлбал, арилжааны болон сурталчилгааны зорилгоор төлбөр авч, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд тамхи, тамхин бүтээгдэхүүний дүрс байршуулсан тохиолдолд илэрхий тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа гэж үзнэ.

Зөвлөмж

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хоригийн хэрэгжилт нь сэтгүүлзүй, уран сайхан, эрдэм шинжилгээний хууль ёсны илэрхийлэл, нийгмийн болон улс төрийн хууль ёсны тайлбарт чөдөр тушаа болох учиргүй. Гэхдээ тамхины хэрэглээ болон тамхин бүтээгдэхүүний сурталчилгааны сэтгүүлзүй, уран сайхан, эрдэм шинжилгээний хууль зорилгоор ёсны илэрхийлэл, нийгмийн болон улс төрийн хууль ёсны тайлбарыг хэрэглэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг Оролцогч талууд авах нь зүйтэй.

Үзвэр үйлчилгээнд тамхины дүрс ашиглах

Кино, театр, тоглоом гэх мэт үзвэр үйлчилгээний орчны аливаа бүтээгдэхүүнд тамхийг дүрслэх нь ялангуяа хүүхэд, залуучуудын дунд тамхины хэрэглээг сурталчлах хүчтэй хэрэгсэл болдог. Тиймээс Оролцогч талууд дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- Үзвэр үйлчилгээний орчны аливаа бүтээгдэхүүнд тамхи, тамхин бүтээгдэхүүнийг дүрслэн үзүүлсэн тохиолдолд тухайн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, түгээлт, сурталчилгаанд оролцоотой компани, байгууллага нэг бүрийн холбогдох гүйцэтгэх ажилтан дээр дурдсан дүрсний төлөө мөнгө, бэлэг, үнэгүй сурталчилгаа, хүүгүй зээл, тамхин бүтээгдэхүүн, олон нийтийн харилцааны дэмжлэг, аливаа үнэ бүхий зүйл өгч/аваагүй гэдгийг баталдаг механизмыг хэрэгжүүлэх;
- Танигдахуйц тамхины брэндийн дүрсийг үзвэр үйлчилгээний орчны аливаа бүтээгдэхүүнтэй зэрэг буюу түүний агуулгатай холбон харуулахыг хориглох;
- Тамхин бүтээгдэхүүн, тамхины хэрэглээ, тамхины дүрсийг харуулсан үзвэр үйлчилгээний аливаа бүтээгдэхүүний эхэнд тамхины эсрэг зааварчилсан сурталчилгааг үзүүлэхийг шаардах;
- Тамхин бүтээгдэхүүн, тамхины хэрэглээ, тамхины дүрсийг харуулсан байдлыг нь харгалзан үзвэр үйлчилгээний аливаа бүтээгдэхүүнд үнэлгээ (тухайлбал, ийм бүтээгдэхүүнд бага насны хүүхэд үзэхийг хориглосон насанд хүрэгчдийн үнэлгээ өгөх), хүүхдэд зориулсан үзвэр үйлчилгээний орчны аливаа бүтээгдэхүүнд тамхин бүтээгдэхүүн, тамхины хэрэглээ, тамхины дүрсийг оруулахгүй байх үнэлгээ, ангиллын системийг хэрэгжүүлэх.

Зөвлөмж

Тамхийг дүрслэн харуулсны төлөө ямар нэг шан харамж аваагүй болохыг болохыг батлах, тамхины брэндийн дурс ашиглахыг хориглох, тамхины эсрэг сурталчилгаа шаардах болон тамхины дүрс харуулсан эсэхийг харгалзан үнэлгээ өгдөг ангиллын тогтолцоог хэрэгжүүлэх гэх мэт үзвэр үйлчилгээний орчны аливаа бүтээгдэхүүнд тамхи, тамхин бүтээгдэхүүнийг дүрслэн үзүүлэхтэй холбоотой тодорхой арга хэмжээг Оролцогч талууд авах хэрэгтэй.

Тамхины худалдааны хүрээн дэх харилцаа холбоо

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тавьсан хоригийн зорилтыг тамхины худалдааны хүрээн дэх харилцаа холбоог хориглохгүйгээр хангаж болно.

Тамхины худалдааны салбарт ажиллагсдад бүтээгдэхүүний мэдээлэл өгөх зорилготой бүрэн хоригт хамаарахгүй тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг тодорхойлон гаргаж, хатуу мөрдөх хэрэгтэй. Ийм мэдээллийн хүртээмжийг худалдааны шийдвэр гаргагчид болон уг мэдээлэл зайлшгүй хэрэгтэй хүмүүсээр хязгаарлах нь зүйтэй.

Тамхины үйлдвэрийн ажилчид, гэрээт нийлүүлэгчид болон бизнесийн хамтрагчдад тусгайлан гүйцэтгэгчид, зориулсан бөгөөд түгээлт нь зөвхөн дээр дурдсан хүрээгээр хязгаарлагддаг тохиолдолд тамхи үйлдвэрлэгчийн гаргасан мэдээллийн товхимлыг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тавьсан хоригт хамааруулахгүй байж болно.

Зөвлөмж

Тамхины худалдааны салбарын харилцаа холбоог зөвшөөрөх үүднээс бүрэн хоригт хамаарахгүй тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг тодорхойлон гаргаж, хатуу мөрдөх хэрэгтэй.

Бүрэн хоригтой холбоотой Үндсэн хуулийн зарчим

Конвенцийн 13 дугаар зүйлийн дагуу бүрэн хоригийг хэрэгжүүлэхэд Үндсэн хууль буюу Үндсэн хуулийн зарчим саад болж байгаа бол тухайн Оролцогч тал уг саад бэрхшээлийн хүрээнд аль болох өргөн хүрээтэй хязгаарлалтыг хэрэглэнэ. “Үндсэн хууль буюу Үндсэн хуулийн зарчмын улмаас” хоригийг хэрэгжүүлэх “боломжгүй байр сууринд” байгаагаас бусад тохиолдолд бүх Оролцогч тал бүрэн хоригийг хэрэгжүүлэх үүрэгтэй байна. Энэхүү үүргийг “тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны бүрэн хориг нь тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бууруулна гэдгийг ойлгох”, “одоо болон ирээдүй хойч үеэ тамхи, тамхины хэрэглээний эрүүл мэнд, нийгэм, байгаль орчин, эдийн засагт үзүүлэх сүйтгэх үр дагавраас хамгаалах” (конвенцийн 3 дугаар зүйл) гэсэн конвенцийн ерөнхий зорилтын хүрээнд тайлбарлана.

Үндсэн хуулийн зарчмыг хэрхэн уялдуулахыг Оролцогч талуудын Үндсэн хуулийн тогтолцоогоор шийдвэрлэнэ гэдгийг зөвшөөрсөн болно.

КОНВЕНЦИЙН 13.4 ДҮГЭЭР ЗҮЙЛТЭЙ ХОЛБООТОЙ ҮҮРЭГ

Конвенцийн 13.2 болон 13.3 дугаар заалтын дагуу Оролцогч талууд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны бүрэн хоригийг хэрэгжүүлэх (эсвэл өөрийн Үндсэн хууль болон Үндсэн хуулийн зарчмын хүрээнд аль болох өргөн хүрээтэй хязгаарлалтыг хэрэглэх) үүрэгтэй. Конвенцийн 13.2 болон 13.3 дугаар заалтын дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй Оролцогч талд зарим хэлбэрийн тамхины бөхтэй оршсоор байж болзошгүй. Түүнчлэн Үндсэн хууль зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа амь болон Үндсэн хуулийн зарчмын улмаас бүрэн хоригийг хэрэгжүүлэх боломжгүй Оролцогч талд өргөн хүрээний хоригийг хэрэгжүүлж эхэлсний дараа холбогдох арилжааны харилцаа холбоо, зөвлөмж, үйл ажиллагааны зарим тун хязгаарлагдмал хэлбэр болон зарим хэлбэрийн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа хэвээр оршиж болзошгүй.

Хориглогдоогүй аливаа хэлбэрийн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа нь конвенцийн 13.4 дүгээр заалтын шаардлагад нийцсэн байна. Тодруулбал, үүнд “тамхины хэрэглээний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө, аюул болон аливаа тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, аюул, ялгаруулах бодис зэргийн талаар худал ташаа, төөрөгдүүлсэн эсвэл буруу сэтгэгдэл төрүүлж болох арга замаар тамхин бүтээгдэхүүнийг сурталчлах бүх хэлбэрийн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох” (13.4(a)), “бүх тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд эрүүл мэндийн болон бусад зохих анхааруулгыг давхар хэрэглэхийг шаардах” (13.4(b)), мөн “хэрэв аль нэг Оролцогч талд бүрэн хориг байхгүй бол хориглогдоогүй тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар тамхины үйлдвэрээс холбогдох төрийн байгууллагад мэдээлэхийг шаардах” (13.4(d)) зэрэг шаардлага багтана.

Тамхины хэрэглээний эрүүл мэндэд үзүүлэх хор нөлөө, аюул болон тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, аюул, ялгаруулах бодис зэргийн талаар худал ташаа, төөрөгдүүлсэн эсвэл буруу сэтгэгдэл төрүүлж болох арга замаар шууд болон шууд бус хэлбэрээр тамхины хэрэглээ болон тамхин бүтээгдэхүүнийг сурталчилсан нэр томъёо, дүрслэл, худалдааны тэмдэг, эмблем, маркетингийн дүр төрх, лого, өнгө, үлгэрлэсэн болон бусад тэмдэглэгээг хэрэглэхийг Оролцогч талууд хориглоно.⁷ Буруу сэтгэгдэл төрүүлж болохуйц “бохь багатай”, “зөөлөн”, “хэт зөөлөн”, “зөөлөвтөр”, “хатуу”, “хэт” зэрэг бусад үг хэллэгийг аливаа хэлээр хэрэглэхийг хориглох хэрэгтэй.⁸

Оролцогч талууд тамхины аливаа зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг дагалдсан эрүүл мэндийн болон бусад анхааруулгыг тухайн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай ижил тод томруун хэмжээнд байлгах шаардлага тавина. Шаардсан анхааруулгын агуулгыг холбогдох эрх бүхий байгууллага тодорхойлох бөгөөд агуулга нь тамхины хэрэглээ, тамхинд донтохтой холбоотой эрүүл мэндийн эрсдэлийг сайтар ухуулж, тамхин бүтээгдэхүүний хэрэглээг бөхөөж, тамхинаас гарах хүслийг нэмэгдүүлэхүйц байна. Үр дүнг дээд хэмжээнд хүргэхийн тулд конвенцийн 13.4(b) заалтын дагуу Оролцогч талуудын шаардсан анхааруулга нь уг конвенцийн 11 дүгээр зүйлд шаардсан тамхин бүтээгдэхүүний савлагаан дээрх анхааруулгатай нийцсэн байна.

⁷ Эдгээр үг хэллэгийг тамхин бүтээгдэхүүний шинж чанар, эрүүл мэндэд үзүүлэх нөлөө, хор уршгийн талаар буруу сэтгэгдэл төрүүлэхэд хэрэглэж болзошгүй хэмээн ажлын хэсэг Үзсэн “өнгө” хэмээх үгийн хамтаар конвенцийн 11.1(a)-аас авсан болно.

⁸ Конвенцийн 11-р зүйлийн удирдамж болон 11.1(a)-с харна уу.

Өөрийн явуулж буй зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар эрх бүхий холбогдох төрийн байгууллагад мэдээлэх шаардлагыг Оролцогч талууд тамхи үйлдвэрлэгчид тавина. Ийн мэдээлэхдээ хуульд заасан тогтмол хугацаанд мэдээлнэ. Уг мэдээлэлд нийтдээ болон брэнд тус бүрээр дараах мэдээлэл багтсан байна. Үүнд:

- Зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны төрөл, агуулга, хэлбэр, хэвлэл мэдээллийн хэрэгслийн төрөл;
- Зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны байршуулалт болон хэмжээ, цар хүрээ;
- Зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд оролцоотой зар сурталчилгааны болон үйлдвэрлэлийн компаниуд гэх мэт холбоотой бүх аж ахуйн нэгж;
- Тухайн Оролцогч талын улс орноос гаралтай хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа болон хүрэх, хүлээн авах газар нутгийн нэр;
- Зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд хэрэглэсэн санхүүгийн болон бусад нөөцийн мөнгөн дүн.

Талууд худалдааны нууцыг чандлан, уг мэдээллийг нийтэд (интернэтээр цацах зэрэг замаар)⁹ ил тод болгоно.

Хориглоогүй зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тамхины үйлдвэрийн зарцуулсан зардлын талаар мэдээлэхтэй холбоотой конвенцийн 13.4 (d)-д заасан үүрэг нь зөвхөн бүрэн хориг хараахан хэрэгжүүлээгүй Оролцогч талуудад хамаарна. Оролцогч талуудад 13.4 дүгээр заалтын дагуу хүлээсэн үүргээс гадна нэмэлт арга хэмжээ хэрэгжүүлэхийг зөвшөөрсөн 13.5 дугаар заалттай холбоотой санал болгосон арга хэмжээнүүдийг бүх Оролцогч тал хэрэгжүүлэх шаардлагатай. Тамхи үйлдвэрлэгчээс бүх зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар мэдээлэхийг шаардах нь бүрэн хоригийг нэвтрүүлэхээр завдаж буй Оролцогч талуудад хоригт тусгагдаагүй аливаа зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа болон тамхи үйлдвэрлэгчийн хоригтой зөрчилдсөн үйл ажиллагааг таньж тогтооход тус болно. Ийн мэдээлэх шаардлага тавих нь тамхи үйлдвэрлэгчийг ердийн нөхцөлд явуулж болох зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанаас татгалзахад хүргэх давхар ач холбогдолтой.

Зөвлөмж

Оролцогч талууд тамхины хориглоогүй зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны аливаа хэлбэрийн талаарх конвенцийн 13.4 дүгээр заалтад тавьсан шаардлагыг биелүүлнэ. Оролцогч талууд худал ташаа, төөрөгдүүлсэн эсвэл буруу сэтгэгдэл төрүүлж болох арга замаар тамхин бүтээгдэхүүнийг сурталчлах бүх хэлбэрийн сурталчилгааг хориглож, эрүүл мэндийн болон бусад зохих анхааруулгыг давхар хэрэглэхийг шаардан, тамхины хориглоогүй зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар холбогдох төрийн байгууллагад тогтмол мэдээлэхийг шаардана. Оролцогч талууд эдгээр мэдээллийг даруй олон нийтэд ил тод болгоно.

⁹ Энэхүү заалт нь конвенцийн зорилтод нийцүүлэн тамхины үйлдвэрийн талаарх төрөл бүрийн мэдээллийг олон нийтэд ил тод байлгах үүргийг ногдуулсан конвенцийн 12-р зүйлийн “с” заалттай нийцэж байна.

НИЙЦТЭЙ БАЙДАЛ

Дотооддоо тавьж буй аливаа хориг, тэдгээрийн хэрэгжилт нь Дэлхийн түвшинд хэрэглэж буй тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хоригийн тулгын чулуу нь байна. Орчин үеийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл болох интернэт, кино хальс, шууд нэвтрүүлэх хиймэл дагуул зэрэг нь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа нэг улс орны хилээс хялбархан хальж, бусад улс оронд өргөнөөр цацагддаг. Түүнчлэн зар сурталчилгааг хувцас, технологийн төхөөрөмж гэх мэт бүтээгдэхүүнтэй холбох явдал нэлээд гардаг бөгөөд тухайн бүтээгдэхүүнийг даган сурталчилгаа нэг улсаас нөгөөд дамждаг.

Олон улсын хамтын ажиллагаа байхгүй бол дотоодын хоригийн үр нөлөө буурч болох нь тодорхой.

Конвенцид нэгдсэн Оролцогч талын нутаг дэвсгэрээс эхтэй хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа

Конвенцийн 13.2 дугаар зүйлд “бүрэн хоригт Оролцогч тал [нэг бүрийн эрхзүйн орчин, техник хэрэгслийн боломжоос шалтгаалан *тухайн улс орны нутаг дэвсгэрээс эхтэй* хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа хамаарна” хэмээн заажээ.

Хориг нь тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт оршин суугчид буюу бусад улсын оршин суугчдад зориулсан эсэхээс үл хамааран тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт хэвлэсэн буюу үйлдвэрлэсэн хэвлэмэл материал, бүтээгдэхүүнд хамаарна. Анх бий болсон улсад зориулагдсан буюу уг улсад хэрэглэж буй хэвлэсэн материал, бүтээгдэхүүн үү эсвэл өөр улсад зориулагдсан, хэрэглэгдэж буй хэвлэсэн материал, бүтээгдэхүүн үү гэдгийг ялгахад бэрхшээлтэй байдаг.

Тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт оршин суугчид эсвэл өөр улсын оршин суугчдад зориулсан эсэхээс үл хамааран тухайн улсын хувь хүн, аж ахуйн нэгжийн интернэт болон технологид бусад хил дамнасан харилцаа холбооны байршуулсан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд энэхүү хориг мөн хамаарна.

Түүнчлэн өөр улсад хүлээн авч болох тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг мэдээллийн хэрэгслээр дамжуулсан хувь хүн, аж ахуйн нэгжид ч энэ хориг мөн хамаарна.

Түүнчлэн гарал үүслийн эх нутагт нь буцааж импортолсон эсэхээс үл хамааран конвенцид нэгдэн орсон Оролцогч талын газар нутгаас гаралтай зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд тавих бүрэн хоригоор тухайн Оролцогч талын иргэн хувь хүн болон хуулийн этгээд - өөр улсын газар нутагт зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Конвенцид нэгдэн орсон Оролцогч талын нутаг дэвсгэрт гаднаас орж ирж буй хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа

Конвенцийн 13.7 дугаар зүйлд “тамхины тодорхой хэлбэрийн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг хориг бүхий Оролцогч тал өөрийн нутаг дэвсгэрт гаднаас орж ирэх хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны тэдгээр хэлбэрүүдийг хориглож, зөрчил гарсан тохиолдолд өөрийн орны хууль тогтоомжийн дагуу

өөрийн нутаг дэвсгэрт зөрчил гарсантай адил шийтгэл торгуулийг ногдуулах хэмжээгүй эрхтэй байна” хэмээн заажээ.

Энэхүү хориг нь өөр улсад хэвлэсэн буюу үйлдвэрлэсэн тухайн Оролцогч талд гаднаас орж ирж буй, уг нутаг дэвсгэрт оршин суугч этгээдэд зориулагдсан хэвлэмэл материал, бүтээгдэхүүнд мөн хамаарна. Оролцогч талууд импортоор орж ирж буй хэвлэсэн материалд түүвэр шалгалт хийж болно. Хэрвээ ийм хэвлэсэн материалыг тухайн Оролцогч талын иргэн буюу аж ахуйн нэгж хэвлэсэн, түгээсэн бол тэдэнд хариуцлага хүлээлгэж, хоригийг боломжит бүрэн хэмжээгээр хэрэгжүүлнэ.¹⁰ Мөн энэхүү хориг нь тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт оршин сууж буй хүмүүст зориулагдсан эсэхээс ул хамааран тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт нэвтэрч болох интернэтийн мэдээлэл, тухайн Оролцогч талын нутаг дэвсгэрт дамжуулан нэвтрүүлсэн буюу хүлээн авсан дуут, дүрст болон дуу-дүрст материалд хамаарна.

Зөвлөмж

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг бүрэн хориг бүхий Оролцогч талууд нь өөрийн нутаг дэвсгэрээс эхтэй хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг дотоод дахь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны нэгэн адилаар хориглоно. Оролцогч талууд өөрийн нутаг дэвсгэрт бусад Оролцогч тал буюу конвенцид нэгдэн ороогүй улс орноос орж ирэх хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хязгаарлах буюу тэдгээрээс урьдчилан сэргийлэх зорилгоор үр дүнтэй арга хэмжээ авахад өөрийн хэмжээлшгүй эрхийг ашиглана. Ингэхдээ зарим тохиолдолд үр дүнтэй аргыг протоколд тусгах шаардлагатай байж болохыг хүлээн зөвшөөрнө.

ХАРИУЦАХ ЭЗЭН

Хариуцах эзнийг маркетингийн бүхий л сүлжээний хамтаар өргөн хүрээнд тодорхойлно. Гол хариуцлагыг тухайн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг анх санаачилсан тамхи үйлдвэрлэгч, бөөний түгээгч, импортлогч, жижиглэнгийн худалдаачид, тэдний төлөөлөгч, холбоотон хамсаатнуудад ногдуулна.

Түүнчлэн тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд өөр олон аж ахуйн нэгж холбоотой байх явдал гардаг бөгөөд энэ тохиолдолд тэдэнд мөн хариуцлага хүлээлгэнэ.

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны үйлдвэрлэл, байршуулалт болон түгээлтэд аж ахуйн нэгжүүдийн оролцоо харилцан адилгүй байдаг тул хариуцлагыг ижил байдлаар хавтгайруулан хүлээлгэж болохгүй. Тамхины ивээн тэтгэх үйл ажиллагааны тохиолдолд хандив өгсөн, хандивыг хүлээн авсан, хандив өгөх/хүлээн авах үйл ажиллагаанд зуучилсан аж ахуйн нэгжүүд хариуцлага хүлээх ёстой. Хэрвээ тамхины зар сурталчилгаанд харилцаа холбоог ашигласан бол уг харилцаа холбоог бий болгох, агуулгыг нь түгээхэд гүйцэтгэсэн үүрэг, түүнийг хянах боломж зэргийг нь харгалзан хариуцлага хүлээлгэнэ. Зар сурталчилгааг тарааж түгээсэн этгээд нь тухайн зар сурталчилгааны агуулгыг мэдэж байсан буюу мэдэх боломжтой

¹⁰ Зарим тохиолдолд Оролцогч талууд бусад улсын харьяат хүмүүсийн эсрэг хориг гаргаж болно. Өөр улсын харьяат иргэнийг хэрхэх тухай асуудал нь хил дамнасан зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны тухай протоколын заалтаар зохицуулагдаж болно.

байсан бол мөн хариуцлагад татагдана. Энэ нь аль ч төрлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, харилцаа холбооны технологи ашигласан бүх тохиолдолд хамаарах ба ялангуяа интернэт, шууд дамжуулалтын хиймэл дагуулаар цацагдсан зар сурталчилгаанд хамаарна.

Бүх хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон харилцаа холбоотой холбогдуулан

- Бичвэр бүхий материал үйлдвэрлэх буюу хэвлэх хүн, аж ахуйн нэгж (зар сурталчилгааны агентлаг, дизайнер, сонин хэвлэл болон бусад хэвлэмэл материал хэвлэгч, кино, телевиз болон радио нэвтрүүлгийн найруулагч, тэмцээн, шууд тоглолтын найруулагч, интернэт, гар утас, хиймэл дагуулын тоглоом үйлдвэрлэгчид)-ийг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд оролцохыг хориглох шаардлагатай.
- Хэвлэл мэдээллийнхэн болон арга хэмжээ зохион байгуулагчид, тамирчид, олны танил алдартай хүмүүс, кино од, урлагийнхан, аж ахуйн нэгжийг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд оролцохыг хориглох шаардлагатай.
- Аналог буюу дижитал хэрэгсэл, харилцаа холбооны үйл ажиллагаа эрхэлдэг бусад аж ахуйн нэгж (нийгмийн сүлжээний сайтууд, интернэтийн үйлчилгээ хангагч, цахилгаан холбооны компани г.м.)-д тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар мэдсэн тохиолдолд хүлээх тусгай үүрэг ногдуулах хэрэгтэй.

Хуулийн этгээдийн хувьд хариуцлагыг хувь ажилтанд бус, байгууллагад хүлээлгэх хэрэгтэй.

Бүрэн хоригийг зөрчсөн тохиолдолд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай холбоотой аливаа гэрээ, хэлэлцээр, тохиролцоог хүчингүйд тооцно.

Интернэтийн хувьд хариуцлага ногдуулж болох аж ахуйн нэгж, байгууллагатай холбоотой таван үндсэн ухагдахуун байдаг. Үүнд:

- *Агуулгын найруулагч* нь агуулгыг боловсруулах шалтгаан болдог буюу агуулгыг боловсруулдаг. Тухайлбал, тамхины компани, зар сурталчилгааны агентлаг болон онлайн түгээлт хийдэг телевизийн хөтөлбөр, кино, тоглоом зэргийг найруулагчид. Агуулгын найруулагчдад боловсруулж буй агуулгад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа оруулахыг хориглох нь зүйтэй.
- *Агуулгыг сонгогчид* гэж агуулгыг интернэтэд тавигдахаас өмнө хэрэглэгчдэд зориулан сонгодог хэвлэлийн газар, байгууллага юм. Агуулга сонгогчдод бэлтгэн гаргаж буй агуулгад тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа оруулахыг хориглох нь зүйтэй.
- *Агуулга байршуулагчид* нь бусдын бүтээсэн агуулгыг интернэт хэрэглэгчдэд зориулан интернэтэд тавигдахаас нь өмнө нэгтгэдэг буюу агуулга хадгалсан интернэтэд холбогдсон компьютерийн серверийг хянадаг аж ахуйн нэгж, байгууллага байдаг. Агуулга байршуулагчдад агуулгыг мэдсэн үедээ тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай холбоотой агуулгыг устгах буюу нэвтрэх боломжгүй болгох үүргийг ногдуулах хэрэгтэй.
- *Агуулгыг удирдагчид* нь агуулгын байршлыг тогтооход нь хэрэглэгчдэд тусалдаг интернэтийн хайлтын хөдөлгүүр мэтийн байгууллагууд юм.

Агуулгыг удирдагчдад агуулгыг Мэдсэн үедээ тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай холбоотой агуулгыг нэвтрэх боломжгүй болгох үүрэг ногдуулах хэрэгтэй.

- *Нэвтрэх боломж хангагчид* нь эцсийн хэрэглэгчдийг харилцаа холбооны үйлчилгээнд холбогч байгууллага, тухайлбал интернэтийн үйлчилгээ хангагч, гар утасны компани зэрэг юм. Нэвтрэх боломж хангагчдад агуулгыг мэдсэн үедээ тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаатай холбоотой агуулгыг нэвтрэх боломжгүй болгох үүрэг ногдуулах хэрэгтэй.

Агуулгын найруулагч, агуулгыг сонгогчид болон агуулгыг байршуулагчдад ногдуулах үүргээс ялгаатай нь агуулгыг удирдагчид болон нэвтрэх боломж хангагчдын үүргийг Оролцогч талууд нэвтрэх боломжийг хаах үүргээр хязгаарлаж болно.

Зөвлөмж

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд холбогдсон аж ахуйн нэгжүүдийг өргөн хүрээнд тодорхойлж, гүйцэтгэсэн үүргийнх нь дагуу хариуцлага хүлээлгэх шаардлагатай.

Гол хариуцлагыг тухайн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг анх санаачилсан тамхи үйлдвэрлэгч, бөөний түгээгч, импортлогч, жижиглэнгийн худалдаачид, тэдний төлөөлөгч, холбоотон хамсаатнуудад хүлээлгэх нь зүйтэй.

Хэвлэл мэдээллийн агуулга боловсруулах болон хэвлэх ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, этгээдэд боловсруулж буй болон хэвлэж буй агуулгадаа тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа оруулахыг хориглоно.

(Олон нийтийн арга хэмжээ зохион байгуулагчид, тамирчид, олны танил нэртэй хүмүүс гэх мэт) хүмүүс, аж ахуйн нэгжүүдийг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд оролцохыг хориглоно.

Агуулгыг устгах зэрэг тодорхой үүргийг тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар мэдсэн аливаа аналог болон дижитал хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй холбоотой байгууллагуудад ногдуулах шаардлагатай.

ТАМХИНЫ ЗАР СУРТАЛЧИЛГАА, ДЭМЖЛЭГ, ИВЭЭН ТЭТГЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ ДОТООДОО ХЭРЭГЖҮҮЛЭХ

Шийтгэл

Оролцогч талууд үр дүнтэй, тохиромжтой шийтгэл (торгууль, залруулга, лицензийг түр түдгэлзүүлэх, цуцлах г.м.)-ийг бий болгож, хэрэглэнэ. Ногдуулсан шийтгэлийг үр дүнтэй хориг болгох үүднээс тэдгээрийг зөрчлийн мөн чанар (эхний удаа гэх мэт) болон ноцтой эсэхийг харгалзан зэрэглэж, тохируулахын зэрэгцээ тухайн зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанаас олж болох эдийн засгийн ашгийг харгалзана.

Үйлдвэрлэгч болон холбогдох аж ахуйн нэгж зөрчлийг давтан гаргасан тохиолдолд илүү шийтгэл ногдуулах шаардлагатай. Олон удаагийн давтан

болон эрээ цээргүй зөрчилд хорих ял гэх мэт илүү хатуу шийтгэл оноох нь зүйтэй. Шийтгэлд мөн зөрчлийг залруулах арга хэмжээ туссан байх ёстой. Үүнд:

- Зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг зогсоох;
- Шүүхийн шийдвэрийг шүүхээс тогтоосон талын зардлаар, шүүхээс тогтоосон байдлаар хэвлэн нийтлэх;
- Залруулах арга хэмжээ буюу сөрөг сурталчилгааг санхүүжүүлэх.

Шийтгэлийг зөвхөн хувь хүнд бус бас байгууллагын үйл ажиллагаанд ногдуулах хэрэгтэй (үүнд мөн дотоодод нөлөө бүхий үйл ажиллагаа явуулсан нутаг дэвсгэрээс гадна орших байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хариуцлага тооцох асуудал хамаарна). Мөн шийтгэлийг байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг хариуцсан менежер, захирал, ажилтан, хууль ёсны төлөөлөгчид ногдуулах шаардлагатай.

Тамхи үйлдвэрлэгчид, импортлогчид, бөөний болон жижиглэнгийн худалдаачдад тусгай зөвшөөрөл олгох нь зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хянах үр дүнтэй арга болж болох юм. Хүсэлт гаргагч нь хуулийн шаардлагыг хангаж байгаа тохиолдолд тусгай зөвшөөрөл олгох буюу сунгаж болно. Хуулийн шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг тодорхой хугацаагаар хураан авах буюу цуцалж болно. Тамхины үйлдвэрлэл, борлуулалтад шууд оролцоогүй хариуцагч буюу холбогдогч аж ахуйн нэгж тусгай зөвшөөрөл авахыг хүссэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, цуцлах шалгуурт тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны заалтыг дагаж мөрдсөн эсэхийг үзүүлэлт болгон оруулах нь зүйтэй.

Хориг шийтгэлийг ногдуулснаар хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллагууд шүүхэд хүргэхгүйгээр (уулзалт, сануулга, захиргааны шийдвэр, тогтмол торгуулийн төлбөр гэх мэтээр дамжуулан) хууль бус үйл ажиллагааг боломжтой байж болох юм.

Шударга ёсны хяналт, хэрэгжилт, хүртээмж

Оролцогч талууд хуулийн хэрэгжилтийг хянаж, хангуулах эрх бүхий, бие даасан байгууллагыг томилж, шаардлагатай эрх мэдэл, нөөцөөр хангах хэрэгтэй. Энэхүү агентлаг нь өргөдөл гомдлын мөрөөр шалгалт хийх, хууль бус зар сурталчилгааг илрүүлэх, өргөдөл гомдлыг шийдвэрлэх, зохих хуулийн үйл ажиллагааг санаачлан эхлүүлэх эрхтэй байна.

Иргэний нийгмийн байгууллагууд болон иргэд нь хоригийг хянаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох шаардлагатай. Иргэний нийгмийн байгууллагууд, тодруулбал нийгмийн эрүүл мэнд, хүүхэд залуучуудыг хамгаалах болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах байгууллагууд нь үр дүнтэй хяналтыг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хуулийн эдгээр этгээдэд зарга үүсгэх эрхийг хууль тогтоомжоор олгох хэрэгтэй.

Түүнчлэн иргэний хуулиар тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглох хэрэгтэй. Сонирхсон дурын этгээд болон төрийн бус байгууллага тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны эсрэг хууль ёсны арга хэмжээ авах боломжийг үндэсний хууль тогтоомжоор олгох хэрэгтэй.

Зар сурталчилгааны хоригийг зөрчсөн талаар иргэд чөлөөтэй гомдол саналаа хүргэх үнэгүй утас, вэб хуудас ажиллуулах болон бусад аргыг ашиглаж болно.

Зөвлөмж

Оролцогч талууд үр дүнтэй, зохистой шийтгэлийг бий болгож, ногдуулна. Оролцогч талууд хуулийн хэрэгжилтийг хянаж, хангуулах эрх бүхий, бие даасан байгууллагыг томилж, шаардлагатай эрх мэдэл, нөөцөөр хангах хэрэгтэй. Иргэний нийгмийн байгууллагууд хуулийн хяналт, хэрэгжилтэд оролцоотой байж, шударга ёсыг дээдэлдэг байх хэрэгтэй.

ОЛОН НИЙТИЙН МЭДЛЭГИЙГ ДЭЭШЛҮҮЛЭХ

Конвенцийн 12 дугаар зүйлийн хүрээнд¹¹ Оролцогч талууд харилцаа холбооны боломжит бүх хэрэгслийг ашиглан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар олон нийтэд сайтар таниулах нь зүйтэй. Оролцогч талууд бүрэн хоригийн ач холбогдлыг таниулах үр дүнтэй, далайцтай олон нийтийн боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөрт хамруулах арга хэмжээг авч, хэрэгцээ шаардлагын дагуу олон нийтийн мэдлэгийн дээшлүүлж, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хүлээн зөвшөөрч болохгүй шалтгааныг тайлбарлана.

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг хориглосон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, зөрчлийг мэдээлэх үйл ажиллагаанд нийгэм, хамт олны тус дэмжлэгийг авах нь хэрэгжилтийг хангахад нэн чухал юм. Нийгмийн гишүүд энэ үүргээ биелүүлэхийн тулд асуудлыг танин мэдэж, хууль болон зөрчил гарсан тохиолдолд авах арга хэмжээг ойлгодог байх ёстой.

Оролцогч талууд олон нийтийн боловсрол, мэдлэгийг Дээшлүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлж, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагад мэдээлэх, хууль зөрчиж тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаанд оролцсон этгээдийн эсрэг арга хэмжээ авах талаар иргэдэд таниулна.

Зөвлөмж

Оролцогч талууд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг арилгах хэрэгцээ, тэдгээрийг хориглосон хууль тогтоомж болон хууль зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээний талаар нийгэмд таниулах ажлыг нийгмийн бүхий л салбарт дэмжиж, бэхжүүлнэ.

ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

Тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг арилгах хүчин чармайлтын үр дүн нь Оролцогч тал нэг бүрийн авч хэрэгжүүлсэн санаачилгаас төдийгүй Оролцогч талуудын хамтын ажиллагаанаас хамаарна. Үр дүнтэй олон улсын хамтын ажиллагаа нь дотоодын болон хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг таслан зогсооход нэн чухал.

¹¹ “Боловсрол, харилцаа холбоо, сургалт, олон нийтэд таниулах”

Конвенцид нэгдэн орсон Оролцогч талууд нь конвенцийн 13.6 дугаар зүйл (хил дамнасан сурталчилгааг таслан зогсооход туслахын тулд технологийн хөгжил болон бусад арга хэрэгслээр хамтран ажиллах), 19 дүгээр зүйл (Хариуцлага), 20 дугаар зүйл (Судалгаа, хяналт шалгалт, мэдээлэл солилцоо), 20.4 дүгээр зүйл (Олон нийтэд нээлттэй шинжлэх ухаан, техник, нийгэм эдийн засаг, арилжаа, эрхзүйн болон тамхины үйлдвэрийн практикийн мэдээлэл солилцоо), 21 дүгээр зүйл (Мэдээлэх болон мэдээлэл солилцох), 22 дугаар зүйл (Шинжлэх ухаан, техник, эрхзүйн салбарын хамтын дугаар зүйл ажиллагаа, экспертиз мэдлэгийг хангах), 26 дугаар зүйл (Санхүүгийн нөөц)-ийн заалтын дагуу олон улсад хамтран ажиллах амлалтаа өгсөн болно.

Энэхүү удирдамжид багтсан зөвлөмжөөс гадна Оролцогч тамхины зар хил дамнасан талуудын бага хурлаас сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг таслан зогсооход тус болох хамтын ажиллагаа болон мэдээлэл солилцооны чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ажлын хэсгийн гаргасан зөвлөмжид Оролцогч талууд анхаарлаа хандуулна.¹² Оролцогч талууд дан ганц хил дамнасан тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагаа бус тамхины нийт зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны талаар мэдээлэл, туршлага, мэдлэгээ хуваалцах нь тустай учраас улс орны дотоод дахь тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээ ч бас үр ашигтай.

¹² Шийдвэр FCTC/COP3(14)

ХАВСРАЛТ

Конвенцийн нөхцөлийн хүрээнд тамхины зар сурталчилгаа, дэмжлэг, ивээн тэтгэх үйл ажиллагааны хэлбэрт тооцогдох хориотой үйл ажиллагааны жагсаалт (иж бүрэн бус)

- Дуут, дүрст болон дуу-дүрст аргаар харилцах. Үүнд: хэвлэл (сонин, сэтгүүл, товхимол, ухуулах хуудас, зарлал, захидал, сурталчилгааны самбар, зурагт хуудас, дохио тэмдэг), телевиз, радио (хуурай замын болон хиймэл дагуулын), дүрс бичлэг, DVD, видео, CD, тоглоом (компьютер тоглоом, видео тоглоом, интернэт тоглоом), бусад дижитал харилцаа холбооны хэрэгсэл (интернэт, гар утас зэрэг), театрын болон бусад шууд тоглолт;
- Үзвэр үйлчилгээний газар, жижиглэнгийн зах, дэлгүүр, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэгт брэнд тэмдэг хэрэглэх (брэнд өнгө, брэнд өнгөний хослол, лого, худалдааны тэмдэг гэх мэт);
- Борлуулалтын цэгүүдэд дэлгэн тавьсан тамхин бүтээгдэхүүний үзүүлэн;
- Тамхин бүтээгдэхүүн худалдаалах машин;
- Интернэтээр тамхин бүтээгдэхүүн борлуулах;
- Брэнд өргөтгөх, брэнд хамтран хэрэглэх (бүтээгдэхүүний нэр төрлийг өргөжүүлэх);
- Бүтээгдэхүүн байршуулалт (төлбөртэйгөөр буюу бусад хэлбэрээр харилцаа холбоо явагдах зуур тамхин бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсвэл тамхины худалдааны тэмдгийг оруулах, холбох гэх мэт);
- Тамхин бүтээгдэхүүний худалдан авалтыг дагалдуулан урамшуулал, бэлэг (түлхүүрийн оосор, дотуур цамц, саравчтай малгай, тамхины асаагуур гэх мэт) эсвэл бүтээгдэхүүний хөнгөлөлт олгох;
- Маркетингийн судалгаа болон амталгаат худалдаатай холбогдуулан тамхин бүтээгдэхүүний үнэгүй дээж тараах;
- Тамхин бүтээгдэхүүний худалдан авалтад дагалдуулан үзвэр үйлчилгээний тасалбар гэх мэт урамшуулал олгох;
- Тамхин бүтээгдэхүүн худалдан авах шаардлагатай болон шаардлагагүй тамхин бүтээгдэхүүн буюу брэндийн нэрэмжит тэмцээн, өрсөлдөөн;
- Телемаркетинг, "хэрэглэгчийн судалгаа", "судалгаа" нэрийн дор сурталчилгааны материалыг хувь хүнд шуудангаар г.м. шууд илгээх;
- Хямдралтай бүтээгдэхүүний сурталчилгаа;
- Тамхин бүтээгдэхүүнтэй ижил төстэй тоглоом, чихэр сэлтийг нийлүүлэх буюу худалдан борлуулах;
- Жижиглэнгийн урамшууллын (тодорхой хэмжээний борлуулалт хийсэн жижиглэнгээр худалдан авагчдад шагнал олгох гэх мэт) хөтөлбөрийг ашиглан жижиглэнгээр худалдан авагчдад бүтээгдэхүүнийг борлуулах түлхэц өгөх;
- Савлагаа болон бүтээгдэхүүний дизайны онцлог;
- Жижиглэнгийн дэлгүүрт, аливаа газар, арга хэмжээн дээр тодорхой нэг бүтээгдэхүүн эсвэл тодорхой нэг үйлдвэрлэгчийн бүтээгдэхүүнийг

тусгайлан борлуулах буюу дэлгэн үзүүлэхээр төлбөр төлөх буюу өөр тохиролцоо хийх;

- Сургалтын байгууллага, аялал жуулчлал, спорт, үзвэр үйлчилгээ, хөгжим, бүжиг болон олон нийтийн газар, арга хэмжээн дээр бүтээгдэхүүнийг худалдан борлуулах, нийлүүлэх, байршуулах болон дэлгэн үзүүлэх;
- Сурталчилгаа хийсэн, эс хийснээс үл хамааран байгууллагын нийгмийн хариуцлагын үйл ажиллагаа зэрэг аливаа арга хэмжээ, үйл ажиллагаа, хувь хүн болон бүлэг (спортын болон урлагийн арга хэмжээ, тамирчин хувь хүн, баг, урлагийн хүн, урлагийн хамтлаг, халамжийн байгууллагууд, улс төрч, улс төрийн нэр дэвшигч, улс төрийн нам г.м.)-т санхүүгийн болон бусад төрлийн дэмжлэг үзүүлэх;
- Тамхины үйлдвэрийн зүгээс шар айрагны мухлаг, клуб, амралт цэнгээний газар гэх мэт үйлчилгээний газруудад санхүүгийн болон бусад төрлийн дэмжлэг үзүүлж, хариуд нь тамхин бүтээгдэхүүнийг сурталчлах газрыг байгуулах буюу засварлах, халхавч, сүүдрэвчээр хангах буюу үйлчлэх.

-оОо-